



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/894

Улаанбаатар хот

Мэдээний нэр төрөл,
жишиг үнэ, тариф батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллагын Агаарын навигацийн үйлчилгээ ба нисэх буудлын үйлчилгээний төлбөрийн талаар баримтлах бодлогын баримт бичиг "ICAO Doc 9082", Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн үйлчилгээнд ашиглах тусгай хэрэгцээний цаг агаарын мэдээний нэр, төрөл, жишиг үнэ, тарифыг хавсралтаар баталж, 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Нисэхийн цаг уурын тусгай хэрэгцээний мэдээгээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчлэхдээ энэхүү үнэ, тарифыг мөрдөж ажиллахыг Ус цаг уур, орчны шинжилгээний газар, түүний харьяа байгууллагын төсвийн шууд захирагч нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газар (Э.Баттулга)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан "Жагсаалт, үнэ батлах тухай" Байгаль орчны сайдын 1998 оны А/16 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Б.БАТБААТАР

1525002229

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн
сайдын 2025 оны 12 дугаар сарын 7-ны
өдрийн 118 дугаар тушаалын хавсралт



НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭНИЙ
НЭР ТӨРӨЛ, ЖИШИГ ҮНЭ, ТАРИФ

Д/д	Мэдээний төрөл	Мэдээний үнэ, тариф (төгрөг)
1	Буудал орчмын бодит ажиглалтын мэдээ (METAR, SPECI)	7,000.0
2	Буудал орчмын богино хугацааны урьдчилсан мэдээ, 9 цаг (TAF)	14,000.0
3	Буудал орчмын урт хугацааны урьдчилсан мэдээ, 30 цаг (TAF)	28,000.0
4	Өндрийн салхины урьдчилсан мэдээ	24,100.0
5	Хөөрөлтийн урьдчилсан мэдээ	14,400.0
6	Нислэгийн бүсийн урьдчилсан мэдээ	14,400.0
7	Чиглэлийн урьдчилсан мэдээ	17,200.0
8	Дунд болон өндрийн нислэгийн аюултай үзэгдлийн мэдээ (SIGMET)	39,600.0
9	Нам өндрийн нислэгийн аюултай үзэгдлийн мэдээ (AIRMET)	81,700.0
10	Хиймэл дагуулын болон Радарын бодит ажиглалтын мэдээ, цаг агаарын зураг	2,000.0

Жич: Нэг мэдээний зардлыг ханшийн зөрүү, инфляцын өсөлттэй уялдуулан тооцов.

----oOo----